



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Байгаль орныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын тайлан



ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Ховд хот

2016 он

Агуулга

Аудитыг гүйцэтгэж тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	
УАГ-ын харьяа Ховд аймгийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл	1
	Оршил	2
Тэргүүлэх аудитор Л.Галбадрах	БҮЛЭГ 1. Аймаг, сумдын ИТХ, Засаг дарга нарын Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан бүрэн эрхийн хэрэгжилтийн талаар	3
Аудитын менежер А.Цэцэгсүрэн	Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан бүрэн эрхийн хэрэгжилт хангалтгүй байна.	4
Ахлах аудитор Д.Хишгээ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг хэрэгжүүлэн орон нутагт хяналт тавих сумын ИТХ, сумын засаг дарга, байгаль орчины улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хуульд заасан үүргээ биелүүлээгүй байна.	5
2016 оны 10 дугаар сар	БҮЛЭГ 2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт Төр захиргааны шийдвэр, төрийн хяналт, холбогдох хууль, тогтоол, журмуудын хэрэгжилт сулаас байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт хангалтгүй байна.	6
Уг тайланг УАГ-ын Веб сайтаас үзнэ үү. www.audit.gov.mn		7-13
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432545 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу.	БҮЛЭГ 3: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын зарцуулалтын талаар Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогыг хувь, хэмжээний дагуу зарцуулахгүй байгаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан заалтыг зөрчиж байна.	14-16
ХАЯГ: Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар Ховд аймгийн Аудитын газар 3 давхар	БҮЛЭГ 4: Байгаль хамгаалах тухай хуулийн дотоод хяналтын талаар Байгаль орчны чиглэлийн бүхий л байгууллагууд чиглэл чиглэлээрээ хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч зөрчил дутагдал буурахгүй байна .	17-18
	Аудитын дүгнэлт	18
	Аудитын зөвлөмж	19
	Тэргүүлэх Аудиторын тушаал	20
	Албан шаардлагын товчоо	21
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:	22
	Хавсралт судалгаанууд.....	23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ААГ	Аймгийн аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын газар
БХС	Байгаль хамгаалах сан
ХУНТХГНХЗ	Хар ус нуурын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа
БЦГ	Байгалийн цогцолборт газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуучлалын газар
Цэцэг МУНБЦГЗ	Цэцэг Мянган Угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын захиргаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗД	Засаг дарга
БОУБ	Байгаль орчны улсын байцаагч
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл

1.1.Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2016 оны 1 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт аймгийн аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

1.2 Аудитын зорилт, хамрах хүрээ: Ховд аймгийн бүх шатны ИТХ, Засаг дарга түүний харьяа байгууллагуудын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэнд нийцлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг ханган биелүүлэхийн тулд дараахь чиглэлээр аудит хийлээ.

- Бүх шатны ИТХ, засаг дарга байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан үүргийг биелүүлсэн эсэх
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрэн төвлөрүүлсэн эсэх
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хувиарласан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан эсэх
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэнд тавихдотоод хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн эсэх

Аудитын зорилтын ханган биелүүлэхийн тулд аймаг, сумдын ИТХ-аар баталсан тогтоол, захирамжууд, аймаг, сумдын татварын орлогын бүрдүүлэлт, 2015 оны байгаль хамгаалах сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тэнцэл, холбогдох бусад материалуудад тулгуурлан гүйцэтгэв.

1.3.Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт хугацаа: Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудит хийх журам, арга зүйг ашиглаж аудитын дүн, дүгнэлтэнд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Ойн тухай хууль, Усны тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Амьтны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газар, холбогдох яам, агентлаг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэр, журмууд, аймгийн Засаг даргын шийдвэрүүдийг шалгуур болгон ашиглав.

Аудитыг аймгийн Тэргүүлэх аудитор Л.Галбадрах удирдаж аудитын менежер А.Цэцэгсүрэн хянаж, ахлах аудитор Д.Хишгээ гүйцэтгэлээ.

Аудитын явцад 6 сумдын байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж томилолтоор ажиллан, байгаль хамгаалах сангаас хэрэгжүүлсэн ажлыг газар дээр нь очиж танилцан хэрэгжсэн ажлуудыг газар дээр нь танилцаж аудитад ашиглав.

1.4 Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Аймаг, сумдын ИТХ, Засаг дарга нарын Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан бүрэн эрхийн хэрэгжилтийн талаар I бүлэгт, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт талаар II бүлэгт, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын зарцуулалтын талаар III бүлэгт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн талаар IV бүлэгт тусган аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал гэсэн агуулгаар бичигдлээ.

ОРШИЛ :

Байгаль орчны багц хууль, УИХ болон Засгийн газрын тогтоол, салбарын сайдын тушаал зэрэг хууль эрх зүйн хүрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг явуулж байна. Байгалийн нөхөн сэргээх асуудал, төсөв санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэгтэй холбогдох байгаль орчин, уул уурхайн хууль журам, бодлогын УИХ-аас батлагдсан хууль 51, УИХ-ын 5 тогтоол, Засгийн газраас гаргасан 6 тогтоол, холбогдох яамдаас гаргасан 10 төрлийн тушаалын дүрэм журмууд өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна.

Байгаль орчны багц хуулиар аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нарт байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, тусгай хамгаалалттай газрын хамгаалалын менежментийг сайжруулах чиглэлээр 60 гаруй төрлийн чиг үүргийг хүлээлгэсэн байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нар хуулиар оногдуулсан эдгээр чиг үүргийг орон нутагтаа хэрэгжүүлэхдээ шаардагдах төсвийг 2012 онд батлагдсан “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хууль, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс бүрдүүлж байна.

Үүнд байгалийн ургамлын, ус, рашааны, ойн, ан амьтаны, газрын нөөц ашигласны төлбөрүүдийн орлогыг санхүүгийн эх үүсвэр болгон ашиглаж байна.

Уг төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлсэнээр аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал баталж хэрэгжүүлж байна.

БҮЛЭГ 1: АЙМАГ, СУМДЫН ИТХ, ЗАСАГ ДАРГА НАРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН БҮРЭН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан бүрэн эрхийн хэрэгжилт хангалтгүй байна.

1.1 Ховд аймгийн хэмжээнд өнөөдрийн байдлаар Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 10 байгууллага 221 орон тоотойгоор 2382,6 сая төгрөгний үйл ажиллагааны зардалтай үйл ажиллагаа явуулж байна.

д/д	Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн байгууллагууд	Нийт зардал	цалингийн сан	батлагдсан орон тоо
1	БОАЖГАзар	340.4	257.5	40
2	Ой анги	35.0	24.1	3
3	УЦОШАлба	962.8	745.1	95
4	Хар нуур Ховд голын сав газрын захиргаа	96.8	77.3	8
5	ГХБХБГазар	258.8	139.4	16
6	ХУНОУТХГНХЗахиргаа	245.2	139.7	19
7	Мөнххайрхан БЦГ	186.7	126.5	18
8	Цэцэг МУНБЦГЗахиргаа	145.9	80.4	12
9	Булган голын сав газрын захиргаа	62.3	27.0	5
10	Ховд Үенч Бодонч сав газрын захиргаа	48.7	24.5	5
Нийт дүн		2382.6	1,641.5	221.0

Дээрхи төрийн байгууллагуудад байгаль хамгаалагчийн хариуцан ажиллах талбайн норматив, улсын тусгай хамгаалалтанд ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтанд авч хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоох эсэх, хот, тосгон,бусад суурин болон амралт, сувилалын газар, гол мөрний эх, нуур,рашаан булаг, шанд, уст цэгийн орчныг хамгаалах,эрүүл ахуйн шаардлагыг хангах тусгай бүсийн заагийг тогтоох эсэх, байгаль орчны байцаагчийн нормын хувцас, ялгах тэмдэг, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах шаардлагатай эсэх харьяалагдах нутаг дэвсгэрийн байгалийн тогтоц, хэв шинж, уул уурхайн олборлолт хийсний улмаас байгаль орчны үнэлгээ хийж байгалийг нөхөн сэргээх шаардлагатай эсэх зэргийн харгалзан улсын болон орон нутгийн төсвөөс хувьсах шинж чанартай 2 тэрбум 346,0 сая төгрөг зарцуулагдаж байна.

Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөөгийн болон ирээдүй үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хооронд үүссэн харилцааг эдгээр байгууллагууд зохицуулж байна.

Эдгээр төрийн байгууллагаас гадна үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудаас гадна ОУ-ын тусламж, дэмжлэгээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд Дэлхийн Байгаль хамгаалах сан, АНУ-ын Азийн сан “ Нөхөн сэргээлтийн ажил, ОУ-ын Тахь групп Швецарийн хөгжлийн агентлагийн санхүүжилт зэргээр маш олон байгууллагууд байгаль орчны чиглэлээр ажиллаж байна. *Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэхэд маш их хүн хүч, материал, санхүүгийн нөөцөөр зохицуулж байгаа нь дээрх тоон үзүүлэлтүүдээс харагдаж байна.*

- 1.2 2015 онд 40 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа Ховд аймгийн БОАЖГ-т 38 удаагийн гадаадын болон дотоодын сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 210 хүн хамрагдаж 10,0 гаруй сая төгрөг зарцуулсан байна. Сургалт явуулж боловсон хүчин чадавхижсанаар үндсэн зорилт чиг үүрэгт томоохон ахьц өөрчлөлт гарах ёстой атал тус хуулийг хэрэгжилтийг шалгах хугацаанд салбар хариуцсан мэргэжилтэнгүүдийн ажилдаа эзэн болох чадвар, аймгийн хэмжээний бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа суурь судалгаа, мэдээлэлийн нэгдсэн сан, хяналт шинжилгээний тоон мэдээ, тайлан хангалтгүй байна.
- 1.3 Монгол улсын Улсын их хурлаас 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр баталсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн дагуу Ховд аймгийн хэмжээнд нийт 21 ерөнхий үнэлгээг хийж гүйцэтгэснээс нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай- 7, нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой- 14 гэж дүгнэсэн боловч үнэлгээ хийлгэсэн эсэх талаар мэдээлэл байхгүй байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 2 дугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 7.4-д зааснаар шинээр барьж буй барилга байгууламжинд үнэлгээ хийхээр хуульчилсан боловч журам батлагдаагүй байгаа нь түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхгүйгээс байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна.
- 1.4 2014 оны тооллогоор 50-иас дээш тонн түүхий нүүрс түлдэг 93 албан байгууллага, аж ахуйн нэгжүүд хамрагдаж 47 утаа гаргадаг нам даралтын зуух ажиллаж байгаагаас шалтгаалан өвлийн улиралд агаарын бохирдол Улаанбаатар хотын утаатай адил хэмжээнд байдаг нь Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан заалтууд хангалтгүй байна.
- 1.5 Ус ашиглаж үйл ажиллагаа явуулж буй тоосгоны ОДЦЭ ХХК, Тунгалаг буянт ХХК, малын өлөн боловсруулах Арслан бар ХХК, цэвэр усны БэБу ХХК, Ховд Өнөр бүл ХХК, Хатан түнгэл ХХК, дулаан үйлдвэрлэл Бадамлах дөл ХХК, авто зам барих Монгол ЛЗ зам гүүр, Түмэн дэлгэрэх ХХК, мод үржүүлгийн Үр жимс хоршоо, Ховд сафари ХХК-ны зэрэг аж ахуйн нэгж байгууллагын ус ашиглах дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрөл олгон гэргээ байгуулж эрхийн бичиг олгосон ч гэсэн усны төлбөрөө төлөөгүй .Эрэл хайгуулын Эф Ви Эс Пи ХХК , Ашид алтай майнинг” ХХК –иуд зөвшөөрөл авалгүйгээр ус ашиглаж байгаа нь Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заалтуудыг зөрчсөн байна.
- 1.6 Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр 2015 онд Засгийн газрын тогтоол, шийдвэрийн 41 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг тооцоход 80,6 хувь , Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд 14 ажил тусгагдаж, биелэлт 94,4 хувь,2015 оны жилийн эцсийн байдлаар Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн ээлжит болон ээлжит бус хуралдаан, тэргүүлэгчдийн тогтоол, хуралдааны тэмдэглэл нийт 10 эрх зүйн акт хяналтанд авч, 85,5 хувь, Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт 28 заалт тусгагдсанаас 2015 оны жилийн эцсийн байдлаар 70 хувь, аймгийн нийгэм эдийн засгийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 21 заалт тусгагдсаныг 80 хувь, БОАЖГ-ын төсвийн шууд захирагчийн аймгийн Засаг

даргатай байгуулсан гэрээний биелэлт 89,9 хувьтай хэрэгжсэн гэж тайлагнажээ.

1.7 .Аймгийн Засаг дарга байгаль хамгаалах тухай хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн “Ногоон хөгжлийн загвар” аймаг болох зорилтыг дэвшүүлэн дараах үр дүн бүхий ажлууд хийгджээ.

- *Ховд аймагт 2013-2015 онуудад 11 компани 89,9 га талбайд ногоон байгууламж хийсэн ба Үндэсний мод тарих өдрийн хүрээнд Буянт голын дагуу 8 га газарт хамгаалалтын хашааг хийлгэн мод тарих үнэдсний өдрийг амжилттай зохион байгуулсан. Мод тарих ажилд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 323 албан байгууллагын 12507 хүн хамрагдаж 109596 ширхэг мод сөөг тарьж 62,6 сая төгрөгийн зардал гаргасан.*
- *“Ногоон хөгжлийн загвар” аймаг болох зорилтын хүрээнд аймгийн ард иргэдийг эрүүл, аюулгүй, цэвэр орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэх нийтийн эзэмшлийн явган зам, “Ногоон хөгжлийн бодлого”-ын төслийг 2015-2030 он хүртэл хугацаатай 5 бүлэг, 4 стратегийн зорилттойгоор боловсруулан мөрдөж байна*
- *Аймгийн нэн ховор, ховор амьтдыг хамгаалах, ашиглах дэд хөтөлбөрийн төслийг боловсруулсан батлуулсан.*
- *Аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 70 тоот тогтоолоор батлуулан ажилласанаар 2015 онд 1103 гадаадын, 14577 дотоодын жуулчин ирсэн байна.*
- *Аймгийн хэмжээнд 19 хогийн төвлөрсөн цэгийн нийт талбайн хэмжээ 394,5 гагаас 250 га талбайг ОНХСангийн 20,0 сая төгрөгөөр, хог хаягдал цэвэрлэх аяныг 15 удаа зохион байгуулж, нийт 120 гаруй тонн хогийг цэвэрлэж хогийн нэгдсэн цэгт хүргэсэн байна.*

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг хэрэгжүүлэн орон нутагт хяналт тавих сумын ИТХ, сумын засаг дарга, байгаль орчины улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хуульд заасан үүргээ биелүүлээгүй байна.

1.8 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 82 дугаар тогтоолоор батлагдсан “Хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийхэд хяналт тавих журам”-ын 3.2 дахь заалтыг үндэслэн тусгай хамгаалалттай газар нутагт гэрээ байгуулж нөхөн сэргээлт хийлгэсэн боловч хэрэгжүүлсэн ажлын үр дүн хангалтгүй байна.

- Цэцэг сумын Цагаан эрэг, Алтай сумын Оцог хад, Халтар уул, Булган сумын Цоохор нуур, Доод нарийн, Үенч сумын Нарийн хар, Оцгийн хөндий, Мөст сумын Нарийн дов, Цагаан давын ам зэрэг газрууд нь улсын тусгай хамгаалалттай газрын



орчны бүс, хязгаарлалтын бүс, усны эх, сав газарт орсон байдаг. Эдгээр газарт нутгийн иргэд болон ААН хууль зөрчин үйл ажиллагаагаа явуулсаар байна.

- Гянтболд/волфрам/ гар аргаар олборлож эвдрэлд орсон Цагаан эрэг хэмээх газарт нөхөн сэргээлт хийлгэх саналыг Баян-Овоо багийн ИНХурал, сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаан болон МУНБЦГ-ын хамгаалалтын захиргааны зүгээс гаргажээ. Улмаар БОНХАЖЯ-ы Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газрын даргаас ирүүлсэн албан тоотын дагуу гар аргаар ашигт малтмал олборлогчид буюу “нинжа” нарын хууль бус үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 13 га газарт нөхөн сэргээлт хийх ажлын гэрээг Цэцэг сумын Засаг дарга болон МУНБЦГ-ын хамгаалалтын захиргааны дарга нар “Ашид алтай майнинг” ХХК-тай байгуулж 2015 оны 07 сарын 09-ээс 2015 оны 10 сарын 09-ний хооронд нөхөн сэргээлтийн ажлыг хийж дуусган хүлээлгэн өгөх үүрэг хүлээсэн байна. 2015 онд тус компани гэрээний хугацаанд нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн гүйцэтгээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байхад ямар ч хариуцлага тооцохгүй, арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүйгээр дараагийн компанитай гэрээ байгуулж мөн газарт дахин нөхөн сэргээлтийн гэрээ байгуулжээ.

- Уг газарт сумын ИТХ-аар тогтоол гаргуулан 2016 онд Цэцэг сумын Баян-Овоо багийн нутаг Цагаан эрэгт нөхөн сэргээлт хийж буй “Өгөөжтэй өв” ХХК-тай нөхөн сэргээлтийн гэрээ байгуулж 2016 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2016 оны 10 дугаар сарын 09-ны хооронд хийж гэрээ байгуулжээ.



Аудитын явцад тус ажлыг гүйцэтгэлтэй танилцахад 2016 оны 10 сарын 9-ны өдөр нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан ч биологийн нөхөн сэргээлтийг эхлээгүй, ажлын гүйцэтгэл 20 хүрэхгүй хувьтай байгаа төдийгүй, зөвшөөрөлгүй ус ашигласан, хог хаягдлын цэггүй, Хятад иргэдийг ажиллуулж буй зэрэг томоохон зөрчлүүд байна. Тус компани Ангиртын голын уснаас шланкаар ус татан вольфром угааж, ашигласан усыг буцаан голд цутгаж урсгаж байгаа байдалтай байна.



БҮЛЭГ 2: БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ

Төр захиргааны шийдвэр, төрийн хяналт, холбогдох хууль, тогтоол, журмуудын хэрэгжилт сулаас байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт хангалтгүй байна.

- 2.1 Байгаль орчныг хамгаалах тухай хуулинд заасанаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавихад шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бөгөөд байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөр, хураамжийн орлого орон нутгийн төсөвт орно гэж заасны дагуу сумын хэрэглэгчдийн төлбөр нь сумын татварын байцаагчаар дамжин сумын төрийн сангийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлж байна.
- 2.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 5 нэр төрлийн орлого төсвийн орлогыг бүрдүүлж байгаа бөгөөд нийт дүнгээрээ 2014 онд 300,3 сая төгрөгний орлого бүрдүүлж байсан бол 2015 онд 372,2 сая төгрөгний орлого бүрдүүлж өмнөх оны гүйцэтгэлээс 71,9 сая төгрөгөөр өссөн байна.

Ховд аймгийн Орон нутгийн төсөвт 2012-2015 онуудад төвлөрүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

д/д	Орлогын нэр төрөл	2012 оны гүйц	2013 оны гүйц	2014 оны			2015 оны			2016 оны
		гүйц	гүйц	төл	Гүй	Зөрүү	төл	гүй	Зөрүү	Төл
1	Ан амьтан барих зөвшөөрлийн хураамж	63.9	144.1	105.7	85.3	20.4	135.0	146.5	-11.5	150.0
2	Газрын төлбөр	86.5	123.1	136.0	103.0	33.0	200.0	119.8	80.2	216.3
3	Ус рашаан ашигласны төлбөр	17.7	38.8	102.8	70.7	32.1	285.4	73.3	212.1	110.0
4	Ойн нөөц ашигласны төлбөр	22.4	21.3	13.2	18.1	-4.9	12.9	10.5	2.4	12.9
5	Байгалийн ургамал ашигласны төлбөр	4.8	11.4	26.5	21.9	4.6	24.3	22.1	2.1	26.0
6	Түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөр	54.9	86.0	144.3	68.7	75.6	316.5	49.0	267.5	112.0
7	Хог хаягдлын үйлчилгээний хураамж		13.8	89.0	38.7	50.3	171.7	53.1	118.6	125.0

Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Ан амьтан барих зөвшөөрлийн хураамж 2014 онд 85,3, 2015 онд 146,5 сая төгрөгний орлого бүрдүүлж өмнөх оноос 61,2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Газрын төлбөрийн орлого 2014 онд 33,0, 2015 онд 80,2 сая , Ус рашаан ашигласны төлбөр 2014-2015 онуудад 32,1-212,1 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д зааснаар агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогын 50 хувиас доошгүй хувийг зөвхөн агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэхэд зарцуулна гэж заасан нь хэрэгжихгүй байна.

2.3. Ховд аймагт угалз агнуурын 2 бүс, тэх агнуурын 8 бүс нутгаас жилд дундчаар 25-30 орчим тэх агнаж, агнуурын нөөц ашигласны төлбөрийг бүрдүүлж байна. 2014 онд 30000 ширхэг загасыг Хар ус, Хар нуураас амьтны сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор барьж сумдын төсвийн орлого бүрдүүлсэн байна.

№	Сумдын нэрс	2014
		Агнаж бариулсан амьтны /загасын/тоо
1	Буянт	8000ш
2	Манхан	2000ш
3	Чандмань	8000ш
4	Дөргөн	8000ш
5	Мянгад	4000ш

2.4.Тусгай зөвшөөрлөөр манай аймгийн Мөст,

Цэцэг, Дуут, Алтай,Үенч сумдын агнуурын бүс нутгаас “Олзворын ан” гэж амьтны илүү үзүүлэлт бүхий эд, эрхтнийг авах зорилгоор тусгай төлбөр төлж агнах, барихыг.Агнуурын нөөц гэдэг нь хэвийн өсөлт, үржилтийг нь алдагдуулахгүй агнах, барих боломжтой агнуурын амьтны тоо хэмжээг Монгол улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор “Байгалийн нөөцийн төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” батлагдсан. Үүний дагуу Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д зааснаар агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогын 50 хувиас доошгүй хувийг зөвхөн агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэхд зарцуулна гэж заасан нь хэрэгжихгүй байна.

Тусгай зориулалтаар /2013-2015/он



2.5.2014 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А-421 тоот тушаалаар 30000 ширхэг загасыг Хар ус, Хар нуураас амьтны сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор барихыг зөвшөөрсөн үүнийг аймгийн ИТХ-ын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 155 дугаар тогтоолоор нуур бүхий сумаар хувиарлан 50% нь агнадаж төлбөр нь тухайн суманд орсон ч бусад үйл ажиллагааны зардалд зарцуулагдсан байна.

2.6. БОЯ-наас 2015 онд 80 саарал чоно агнах зөвшөөрлийн бичиг ирсэн бөгөөд аймгийн ИТХ-аар батлуулан сумуудад агнуурын зөвшөөрлийг зохион байгууллаагүйгээс 9,6 сая төгрөгийн орон нутгийн орлого бүрдүүлэх боломжийг алдсан байна.

МУЗГ-ын 1997 оны 6 дугаар сарын 25-ны 152 дугаар “ Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай ” тогтоолоор тогтоосон газрын суурь үнэлгээ өнөөдрийг хүртэл шинэчлээгүй мөрдөж байгаа нь өнөөгийн хэрэгцээ, шаардлаганд тохирохгүй байна.

2.7. Энэ тогтоолтой уялдуулан Ховд аймгийн 17 сумын ИТХ-аас дараах тогтоолуудыг гарган одоог хүртэл мөрдөн ажиллаж байна. 17 сумдын Газрын төлбөрийн талаар баримтлан ажиллаж байгаа тогтоолуудыг үзүүлбэл:

д/д	Сумдын нэрс	Огноо	№	Товч утга
1	Алтай	12/29/2007	7/06.	Иргэн,төсөвт байгууллагын эзэмшлийн газарт ногдуулах төлбөрийг 0.5 %, иргэний аж ахуйн зориулалтаар болон аж хауйн нэгжийн эзэмшлийн газарт ногдуулах газрын төлбөрийг 0.7 %, бэлчээр, хадлан, тариалангийн газрын төлбөрийг 0.02% тогтоосон .

2	Булган	12/21/2000	06/.	Булган сумын эзэмшил, ашиглаж байгаа хэсгийн бүсчлэл тогтоож 1 га газрын төлбөрийг 8000-80000 төгрөгөөр тогтоосон.
4	Буянт	12/15/2009	45/.	Буянт сумын иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтанд байгаа газарт газрын суурь үнэлгээ 8.0 сая төгрөгний 0.1%-0.8 % хүртэл тогтоосон байна.
4	Дарви	7/25/1997	04/.	Нэг хонин толгойд ногдуулах бэлчээрийн газрын төлбөрийн хязгаарыг 0.02%, 1 га тариалан, хадлангийн газрын талбөрийн хязгаарыг 0.03%, Зам шугам сүлжээний газрын 1 км тутмын газрын төлбөрийн хязгаарыг 7500 төгрөгөөр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшиж буй газарт газрын суурь үнэлгээ 8.0 сая төгрөгний 0.1%-0.5% -иар тогтоосон байна.
5	Дөргөн	7/17/2009	3/4.	Дөргөн сумын иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтанд байгаа газарт газрын суурь үнэлгээ 8.0 сая төгрөгний 0.3%- 1 % хүртэл тогтоосон байна.
6	Дуут	10/10/2007	7/04.	Дуут сумын иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтанд байгаа газарт газрын суурь үнэлгээ 8.0 сая төгрөгний 0.3%- 1 % хүртэл тогтоосон байна.
7	Зэрэг	12/28/2007	6/07.	1 га тариалангийн газраас авах жилийн төлбөрийн доод хязгаар 174 төгрөг, засварлах итгэлцүүр 0.03%, 1 м2 сум, суурин газраас авах жилийн төлбөрийг 800 төгрөгөөр , засварлах итгэлцүүрийг 1.0%-иар тогтоосон
		4/10/2006	09/.	Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээг тогтоохдоо засварлах итгэлцүүрийг 0.6, 1м2 талбайн үнэ 480 төгрөг, Дэлгүүр, ТҮЦ, билльярд, гуанзны эзэмшлийн газраас авах газрын төлбөрийг жилд 1 удаа 1500-3000 төгрөг, Эзэмшлийн гэрчилгээтэй өвөлжөө, хаваржаа тус бүрээс 750 төгрөгөөр тогтоосон байна.
8	Манхан	12/28/2002	3/7.	Манхан сумын иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтанд байгаа газарт газрын суурь үнэлгээ 8.0 сая төгрөгний 0.3%- 1 % хүртэл тогтоосон байна. ХААН газрын төлбөрийг 274-521 төгрөгөөр тогтоосон байна.
9	Мянгад	12/27/2007	7/4.	1 га тариалан, хадлангийн газрын төлбөр 802.9, тариалангийн талбай 521.4, өвөлжөө, хаваржаа м2-аас 8 төгрөг, Зам шугам сүлжээний газрын 1 км тутмын газрын төлбөрийн хязгаарыг 4500 төгрөгөөр, Мянгад сумын иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтанд байгаа газарт газрын төлбөр 8000-80000 төгрөгөөр тогтоосон байна.
10	Мөст	12/30/2009	6/.	Иргэн аж ахуйн нэгж байгууллагын ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газар 0.1%-иар, ШТС-ийн газрыг 1 % -иар тогтоосон.
11	Мөнххайрхан	12/24/2007	29/.	Суурин газрын нутаг дэвсгэрийн 1-р бүсэд 1м2 газрын суурь үнэ 800 төгрөг, 2 дугаар бүсэд 480 төгрөг, 1 га газрын төлбөрийн хэмжээ 4000-80000 төгрөгөөр тогтоосон байна.
12	Үенч	6/16/1999	07/01.	Сумын төвд байгаа айл өрхийн ахуйн хэрэгцээнд эзэмшиж буй газрын төлбөрийг 8000 төгрөг, 0.07га-гаас илүү талбайгаас 0.2%-иар, хадлан, тариалангийн талбайгаа 0.03%-иар, сумын иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтанд байгаа газарт газрын төлбөр 5000-80000 төгрөгөөр тогтоосон байна.
13	Ховд	12/30/2009	5/6.	Эзэмшиж ашиглаж байгаа 1 га тариалан, хадлангийн газрын төлбөрийн 0.03 %-иар, өвөлжөө, хаваржааны газрын хэмжээг 1 малчин өрхөд 0.4 га-гаар тооцон газрын үнэлгээний 0.1%-иар 4000 төгрөг, сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагад 0.5%, аж ахуйн нэгжид 1%-иар тогтоосон байна.
14	Цэцэг	12/29/2008	2/07.	Сумын иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтанд байгаа газарт газрын суурь үнэлгээ 8.0 сая төгрөгний 0.3%- 1 % хүртэл тогтоосон байна.
15	Чандмань	3/26/2010	17/.	Сумын иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтанд байгаа газарт газрын суурь үнэлгээ 8.0 сая төгрөгний 0.3%- 1 % хүртэл тогтоосон байна. ХААН газрын төлбөрийг 274-521 төгрөг, өвөлжөө, хаваржаа эзэмшигчийн эзэмшил тутмаас 2000 төгрөг,Зам шугам сүлжээний газрын 1 км тутмын газрын төлбөрийн хязгаарыг 1500 -7500 төгрөгөөр тогтоосон байна.
16	Эрдэнэбүрэн	12/29/2009	07/04.	Өвөлжөө, хаваржаа эзэмшигчийн эзэмшил тутмаас 1500 , газар тариалан га - 5000, худалдаа үйлчилгээний зориулалтаар 3000, иргэн аж ахуйн эзэмшиж байгаа газраас м2-аас 8 төгрөгөөр тогтоосон байна.
17	Жаргалант	12/25/2006	05/.	Иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтанд байгаа газарт м/кв-аас 5-15 төгрөг, амины хашааны худалдаа ахуйн үйлчлгээний зориулалтаар ашиглаж буй газраас метр харгалзахгүй 5.0-10.0 мянган төгрөг, Автограж, вагончик, Түц - метр харгалзахгүй 3.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Иргэн аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газрын төлбөр нь 1997 оны 152 дугаар тогтоолыг үндэслэн аймаг сумдын ИТХ-аас тогтоосон газрын төлбөр маш бага төдийгүй сумуудын тогтоосон төлбөрийн хэмжээг харилцан адилгүй тогтоосон байна

2.8 Аймгийн хэмжээний нийт газрын 1 хувь буюу 14175 га газарт газрын төлбөр ногдуулсан төдийгүй нэг иргэний төлөх төлбөрийн хэмжээ хэт бага байна.

2.9 Нэг айлын хашааны зориултаар эзэмшиж байгаа газрын төлбөрт төлөх татвар жилд 100 төгрөг байгаагаас шалтгаалан орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэхэд дөхөм болгож , газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах шаардлагатай байна.

Усны тухай хуулийн 31.1-д Ус ашиглагч иргэн,аж ахуйн нэгж, байгууллага нь ус,рашаан нөөц ашигласны төлбөр төлнө гэсэн хуулийн заалт хэрэгжээгүй бөгөөд ус, рашаан ашигласны төлбөрийн ноогдуулалт хангалтгүй байна.

2.10. Аймгийн төсвийн орлогын тайлангаас үзэхэд Ус рашаан ашигласны төлбөр 2014 онд 32,0, 2015 онд 212,1 сая төгрөгөөр тасарч, 2015 оны төлөвлөгөөнөөс 175,4 сая төгрөгөөр багаар 2016 оны ус рашаан нөөц ашигласны төлбөрийн төлөвлөгөө баталсан байна.

2.11. Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг хэрхэн үндэслэлтэй хийсэн тухай Ховд голын сав газрын захиргаа, БОАЖГ, Үенч , Булган голын сав газрын захиргаа зэрэг мэргэжлийн байгууллагуудаас Ус ашигладаг байгууллагуудын талаар гаргасан дүгнэлт, судалгааг гаргуулан авч хянахад: Байгаль орчин, аялал жуучлалын газраас 2015 онд Ус ашиглагч 15 аж ахуйн нэгжээс 477137,9 м3 ус ашиглаж 347,4 сая төгрөг, Ховд голын сав газрын захиргаанаас Ус ашигладаг 18 аж ахуйн нэгжээс 132764 м3 ус ашиглаж, 23,0 сая төгрөгний усны төлбөр ногдуулахаар тус тус гарган ирүүлсэн байна. Үенч Булган голын сав газрын захиргаанаас иргэн бүрт усны төлбөр ногдуулсан судалгаанаас өөр материал ирүүлсэнгүй .

2.12. Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргаа нь 2015 онд Усны тухай хуулийн 28,4, БОНХС-ын 2013 оны А/157 тоот тушаалыг үндэслэн ЖИАНГСҮ-ЖИАНДА констракшны 6 кепнээс ус ашиглуулах дүгнэлт гаргасны төлбөр 1,8 сая төгрөгийг тус байгууллага урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан.

2.13. Мэргэжлийн байгууллагаас ус ашигласан аж ахуйн нэгж байгууллагад дүгнэлт гарган усны төлбөрийг ЗГ-ын тогтоолын дагуу тогтоосон байхад Шим Ус ХХК, Дөргөний усан цахилгаан станцаас бусад байгууллага, аж ахуйн нэгжүүд усны төлбөрөө төлөөгүй байна. Тухайлбал: МоЭнКо –ХХК -299,6 , Бадамлах Дөл ХХК 0,8, Ховд Сафари, Үр жимс зэрэг мод үржүүлгийн компаниуд, Арслан бар хоршоо –малын өлөн боловсруулах үйлдвэр, Мянгад сум Тоосгоны үйлдвэрүүд - 1,2, Хятадын хатуу хучилттай авто зам барьж буй компаниуд 3,5 сая төгрөгийг тус тус төлөөгүй байна.

Төрийн захиргааны төв байгууллага, Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгалийн баялгийг

ашиглах гэрээ байгуулах, уг гэрээний дагуу байгалийн баялгийг ашиглах газрыг зааж өгөх, Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд байгалийн баялгийг зохих төлбөр, хураамжийг төлж, гэрээ, тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичгийн дагуу ашиглаж болно гэсэн хуулийн заалтууд хэрэгжихгүй байна.

2.14. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 3 дугаар хуралдааны 2013 оны 08 дуугаар сарын 04-ний өдрийн 3/05 тоот тогтоолоор аймгийн хэмжээнд зохих хууль тогтоомжийн дагуу ашиглаж буй Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөрлийн хураамжийг 1.1-Иргэнд ахуйн хэрэглээнд нэг удаа 3000 төгрөг, бусад нөхцөлд жилд нэг удаа 50000 төгрөг 1.2-Аж ахуйн нэгжид жилд нэг удаа 50000 төгрөг байхаар баталсан байна. Баталсан хураамжийн хэмжээг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдсөн байна.

2.15. Байгалийн ургамал ашигласны төлбөр, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого нь 2014 онд 125,6 , 2015 онд 390,6 төгрөгөөр тасарсан байна.

Түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласан төлбөрийг нөөц боломжоо ашиглан өндөр төлөвлөгөө батласан ч гэсэн оруулах ёстой орлогоо бүрдүүлж чадахгүй байна.

2.16. БОАЖГ-ын мэргэжилтэний гаргаж ирсэн судалгаанаас үзэхэд 17 сумын газар нутгаас хайрга, элс, шар шавар, давс хужир, цавын чулуу зэрэг байгалийн баялагуудаас 43,2 га талбайгаас 6770,5 тн хайрга, 23,5 га талбайгаас 3669,2 тн элс, 34 га талбайгаас хичнээн чулуу ашигласан нь тодорхойгүй , 128,7 га талбайгаас 11775 тн шар шавар, шороо зэрэг байгалийн баялаг ашиглаж 38,9 сая төгрөгний орлого бүрдүүлэхээр гаргаж өгсөн судалгаа нь бодит байдалтай нийцэхгүй байгаа бөгөөд Аймгийн төв талбайг шинэчлэх болон бусад гудамж замыг шинэчлэхэд хичнээн хэмжээний чулуу орсон, хэнтэй гэрээ хийсэн тухай холбогдох мэргэжилтэнгүүдээс асуухад мэдэхгүй байгаа нь БОГ-ын мэргэжилтэнгүүд ажлаа бүрэн мэдэхгүй байгаа нь харагдаж байна.

2.17. 2015 онд ТТАМАТ-аас 316,5 сая төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 49,0 сая төгрөг бүрдүүлж, 267,5 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөгөө тасалсанаас үзэхэд өндөр төлөвлөгөө батласан ч гэсэн оруулах ёстой орлогоо бүрдүүлж чадахгүй байна.

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
III.1.1.3	Аврах гал унтраах ангийн барилга /Ховд, Булган сум/	2011	2016	1,022.40	182.7
X.1.16	Төв талбайн шинэчлэл /Ховд, Жаргалант сум/	2012	2016	1,219.90	347.5
XII.1.1.8	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Булган сум/	2014	2017	1,436.30	450
XII.1.1.67	Дотуур байрын барилга /Ховд, Мөст сум/	2013	2016	1,050.00	350
XII.1.1.144	Сургуулийн барилгын үлдэгдэл санхүүжилт, 320 суудал /Ховд, Булган сум/	2012	2016	1,860.00	314.9

XIII.1.1.10	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5 км /Ховд, Жаргалант сум/	2014	2016	2,900.00	725
XVII.1.1.11	Нэгдсэн эмнэлгийн барилга 50 ор /Ховд, Булган сум/	2015	2018	6,659.90	1,000.00
XVII.2.1.10	Спорт цогцолборын барилга /Ховд, Манхан сум/	2012	2017	2,118.00	839.2
67	Аймаг, дүүргийн доторх гудамж, зам, талбайн тохижилт, шинэчлэл /Улаанбаатар, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Ховд/	2015	2016	5,450.00	625.20
108	Сумын төвийн шинэчлэл төсөл /Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Өвөрхангай, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Өмнөговь, Төв, Увс, Ховд, Хэнтий, Хөвсгөл аймагт тус бүр нэг сум/	2014	2016	80,000.00	694.90
Нийт дүн				103,716.50	5529.4

2.18. Түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөрийг өмнөх онуудад Аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын материал, судалгаанд үндэслэн тооцлоо. Тухайлбал: Зэрэг сумын хүүхдийн Цэцэрлэг, Хөгжлийн төвийн барилгад ашиглах ТТБА-төлбөр барилгын зураг төсөвт тусгагдсанаар 8,6 сая , Аймгийн ИТХ-ын 10 дугаар хуралдааны 10/04 тоот тогтоолоор батлагдсан үнэлгээгээр тооцоход 1,9 сая, сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан үнэлгээгээр 2,1 сая төгрөг төлөх тооцоо гарч байна.

Цэцэрлэг/ төсөвт өртөг -1126.0 сая					ТТАМ-ын төлбөрийн тооцоо			
Түгээмэл тархацтай байгалийн баялаг	х/н	Тоо	Нэгж үнэ	Зураг төсвөөр тооцсон төлбөр зохих татвар	2012-10/26-ны аймгийн ИТХуралдааны 10/04 тоот тогтоолоор батлагдсан үнэлгээ	Аймгийн ИТХ-ын батлагдсан үнэлгээрээр Төлбөр зохих төлбөрийн дүн	сумын ИТХ-ны тогтоолоор батлагдсан үнэлгээ	Сумын ИТХ-ын батлагдсан үнэлгээрээр Төлбөр зохих төлбөрийн дүн
Ус	м3	545.4	1000	545400				
Уулын элс	м3	155.6	6500	1011400	1600	248960	1000	155600
Хайрга элс	м3	343.7	6000	2062200	2000	687400	3500	1202950
Голын элс	м3	29.8	6500	193700	1600	47680	1000	29800
Дүн				5757500	1600	478720	1000	299200
Хүүхэд хөгжлийн төв/ төсөвт өртөг 400,0 сая						1462760		1687550
Ус	м3	143.8	1000	143800				
Уулын элс	м3	119.2	15000	1788000	1600	190720	1000	119200
Хайрга	м3	95.4	6500	620100	2000	190800	3500	333900
Голын элс	м3	47.7	6500	310050	1600	76320	1000	47700
Дүн				2861950		457840		500800
Нийт дүн				8619450		1920600		2188350

Дээрхи тооцонд үндэслэн 1 м2 –ийн өртөг зураг төсвөөр 11000 төгрөг бөгөөд нийт Ховд аймагт 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 10 обектоос 5529,4 сая төгрөгний хөрөнгө оруулалтын ажил хийгдэх бөгөөд эдгээр хэрэгжих болон хэрэгжиж дуусаад байгаа обектуудаас дундаар 45,0 сая төгрөгний орлого бүрдүүлэх боломж байна.

2.19. Хувийн хэвшлийн компаниудыг барьж буй Эсба-гийн 9 давхар, Турлиах , Прогресс сургуулийн замын хойд талд баригдаж буй 4 компаний барьж буй орон сууцууд, Баруун монгол Энтернейшель компанийн орон сууц , ТОСК-ийн Ховд аймагт баригдах түрээсийн орон сууц гэх мэт ойролцоогоор 300 гаруй айлын орон сууц ашиглалтанд орох урьдчилсан тооцоонд үндэслэн түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 1 айлын орон сууцанд дундаар 40 м2-аар тооцон 12000 м2-д ноогдох татварыг тооцвол $(2246420/216\text{м}^2=10400)$ 124,8 сая төгрөгийн төлбөр ноогдож байгаа зэргээс үзэхэд нөөц боломж их байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг өмнөх оны гүйцэтгэлээс их төлөвлөсөн байна.

2.20. 2013-2015 оны хооронд Үенч, Мөнххайрхан, Ховд, Мянгад зэрэг 4 сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаас хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг баталсан иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны тогтоолыг ирүүлж, бусад сумдууд Хог хаягдлын үйлчилгээний хураамж баталсан шийдвэрүүдээ ирүүлээгүйгээс үзэхэд хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.21. Хог хаягдлын хураамжийн хэмжээг 16 сумын төвийн 3924 , Жаргалант сумын 7840 бүгд 11764 өрхөөс дунджаар 2000 төгрөгний хогны үйлчилгээний хураамж авахаар тооцвол 23,5 сая, Ховд аймгийн хэмжээнд 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргаж тушаасан 1326 аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвийн 177 бүгд 1503 байгууллагаас дунджаар 30,0 мянган төгрөгний хогны хураамж авахаар тооцвол 45,0 сая төгрөг бүгд 68,5 сая төгрөгний орлого бүрдүүлэх тооцоо гарч байна. 2015 онд хогны үйлчилгээний хураамжаас 171,7 сая төгрөгний орлого бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 53,1 сая төгрөгний орлого бүрдүүлж, 118,6 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарч , 2016 онд 125,0 сая төгрөгний орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн нь өмнөх гүйцэтгэлээс өндөр байна.

БҮЛЭГ 3: БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ЗАРЦУУЛАЛТ


Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогыг хувь, хэмжээний дагуу зарцуулахгүй байгаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан заалтыг зөрчиж байна.

3.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.4-т “Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлсэнээр аймаг, нийслэл, сумыг Иргэдийн төлөөлөгчдийн хурал батална” гэж заасны дагуу БХСанд төвлөрүүлэхээр баталсан байна.

3.2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулинд тусгай сангийн санхүүжилтийг Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Аймгийн Төрийн санд тусгай данс байршуулж зарцуулж байна.	байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь , хэмжээний доод хязгаар/нийт орлогын дүнгээс хувиар/
Орлогын нэр төрөл	
Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого	30 хувь
Ан амьтан барих зөвшөөрлийн хураамжийн орлого	50 хувь
Газрын төлбөрийн орлого	30 хувь
Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь
Ус рашаан ашигласны төлбөрийн орлого	55 хувь

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах , байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараахь байдлаар тогтоосон байна.

3.3.Байгаль орчныг хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх зориулалтаар зарцуулах хөрөнгийн хэмжээг Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээг баримтлан орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тооцно гэж Засгийн газрын тогтоолд заасны дагуу 2014 онд байгалийн нөөц ашигласны орлогоор 300,3 сая төгрөгний орлогоос 136,4, 2015 онд 372,2 сая төгрөгний орлого бүрдүүлснээс 164,9 сая төгрөгийг байгаль хамгаалах санд төвлөрүүлэхээр баталсан .



Байгаль хамгаалах сангийн төлөвлөлт: /сая төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	Хуулийн Хувь	2012 оны гүйц		2013 оны гүйц		2014 оны гүйц		2015 оны гүйц		2016 он	
		Орлогын дүн	БХС	Орлогын дүн	БХС	Орлогын дүн	БХС	Орлогын дүн	БХС	Төл	
Байгалийн ургамал ашигласны төлбөр	30	4.8	1.4	11.4	3.4	24.1	7.2	22.1	6.6	26.0	7.8
Ан амьтан барих зөвшөөрлийн хураамж	50	63.9	32.0	144.1	72.0	79.5	39.8	146.5	73.2	150.0	75.0
Газрын төлбөр	30	86.5	25.9	124.4	37.3	103.2	31.0	119.8	35.9	191.3	28.7
Ойн нөөц ашигласны төлбөр	85	22.4	19.1	21.3	18.1	23.4	19.9	10.5	8.9	12.9	10.9
Ус рашаан ашигласны төлбөр	55	17.7	9.7	39.0	21.4	70.0	38.5	73.3	40.3	110.0	38.5
НИЙТ ДҮН		195.3	88.1	340.1	152.3	300.3	136.4	372.2	164.9	490.1	160.9

Аймгийн байгаль хамгаалах санд 2014 онд 136,4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөгдсөнөөс, гүйцэтгэлээр 75,0 сая төгрөг зарцуулж орлогын гүйцэтгэлтэй уялдуулан батлагдсан төлөвлөгөөнөөс 61,4 сая төгрөгөөр дутуу, 2015 онд 164,9 сая төгрөг зарцуулахаас 104,8 сая төгрөг зарцуулж 60,1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсанаас үзэхэд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний дагуу зарцуулахгүй байгаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан заалтыг зөрчсөн байна.

3.4.Байгаль хамгаалах сангийн сүүлийн хоёр жилийн гүйцэтгэлээс үзэхэд 2014-2015 онд булаг тохижуулахад 4,2, бусад арга хэмжээнд 41,3, мод тарих 45,6, мэдээлэлийн төв байгуулахад 9,0, ногоон байгууламж, хайс хашлага хийх 30,0,

Ажлууд	2014	2015	Дүн
Булаг тохижуулах	1.2	3.0	4.2
Бусад	26.0	15.3	41.3
Мод тарих	23.3	22.3	45.6
Мэдээлэлийн төв байгуулах		9.0	9.0
Ногоон байгууламж		30.0	30.0
Сургалт	5.4	6.3	11.7
Хог цэвэрлэх	19.0	19.0	38.0
Нийт дүн	75.0	104.8	179.8

сургалт суртчилгаа хийхэд 11,7, хур хог цэвэрлэхэд 38,0 бүгд 179,8 сая төгрөг зарцуулжээ.

3.5. Аймгийн БХСангаас хөрөнгийн зарцуулалтыг хянахад дараахь ажлуудыг хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- ✚ Ховд гурван цэнхэр хоршоотой гэрээ хийж Ховд аймгийн Жаргалант сумын их бага 2 голын дунд мод тарих хашаа татах ажлыг 6,0 сая төгрөгөөр хийж хүлээлгэн өгсөн байна.
- ✚ Эрч хүч ОНӨААТҮГ- тай 2015 оны 7-р сарын 01-ны өдөр хүлээлгэн өгөхөөр Ховд аймгийн төв 4 зам дагуух ногоон байгууламжийн хашлага хийх ажлыг 29,9 сая Хур хог цэвэрлэх зардалд 20,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.
- ✚ ХИС-ийн БШТС-ийн химийн тэнхимийн 414 тоот өрөөнд “Экологи сургалт, суртчилгааны мэдээлэлийн төвийн үйл ажиллагаа явагдаж байна. Экологийн төвдөө 2015 оноос Аймгийн Байгаль хамгаалах сангаас 2,4 сая төгрөгөөр 64 төрлийн 221 гаруй ном, гарын авлага, 32 төрлийн 431 гаруй боршур материал бүхий номын фондтой номын сантай болсон байна.
- ✚ Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсаны хүрээнд 2015 онд АНУ-ын Азийн сантай Алтай, Булган, Үенч сумдад эвдрэлд орсон газруудад нөхөн сэргээлт хийх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулан орон нутгийн оролцоо болох 6,0 сая төгрөг шилжүүлсэн байна.

3.6. Дараахь ажлууд ажлын гүйцэтгэл үр дүн хангалтгүй байна.

- ✚ Жаргалант төгс ирээдүй хоршоотой. Төв гудамжны зам дагуу 7400 ширхэг шар хуас, хайлаас тарихаар гэрээ хийсэн боловч санхүүжилтийн хугацаа оройтсон гэсэн шалтгаанаас өнөөдрийг хүртэл хүлээн аваагүй хөрөнгийн үр ашгийг бууруулж байгаа тул албан шаардлага бичлээ.
- ✚ Цэцэг сумын Яргайтын булаг хамгаалах ажлыг 12 жилийн сургуулийн эко клубын багш, сурагчид хамтран 3,0 сая төгрөгөөр төмөр саадан хашаа татсан сүүдрэвч, сандал ширээ, хогийн сав, суртчилгааны самбар байрлуулан сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн ч хулгайд алдагдаж тус ажлын хөрөнгө оруулалт үр дүнгүй болжээ.
- ✚ Аймгийн сум дундын Ойн анги нь 2 га газарт ойжуулалт хийхээр 4,0 сая төгрөгний гэрээ байгуулан уг ажлыг гүйцэтгэсэн боловч тухайн газар нь цэвдэгтэй учраас мод ургах боломжгүй суулгасан шон нь ялзарч унасан тул хашааг буулгаж хураасан байна.
- ✚ Ойн зурваст Ховд Сафари ХХК, Үр жимс хоршоо, Жаргалант төгс ирээдүй хоршоо 40,0 сая, Аймгийн БХСангаас 2014 онд тус газарт Улам дэлгэрэх төгөл нөхөрлөл, Ховд ой ан интернейшнел ХХК -ууд тус бүр 600 м газарт ойн зурвас байгуулахаар нийт 10,0 сая бүгд 50,0 сая төгрөгний ажлыг өөр газарт дахин хийлгэхийг Аймгийн удирдлагуудад үүрэг болгов.
- ✚ “Уурхайт” ЗГБХНөхөрлөл нь Буянт сумын Цагаан бургас багийн нутаг Хар ус нуурын баруун хаяанд 600м х 80м буюу 5 га талбайг шинээр

байгуулахаар гэрээ байгуулсан ч газраа өөрчилсөн, 1.5м өндөртэй хар модон шонгоор хүрээлж, 135см өндөртэйгээр 5 эгнээ өргөст тор татаж хамгаалж, дотор нь тарьсан модоо гараар услаж байна. Уурхайт нөхөрлөлийн гүйцэтгэсэн ойжуулалт хамгаалалтын хашаа татсан боловч тарьсан мод стантартын шаардлага хангахгүй, усалгаа арчилгаа хангалтгүй байна.

- ✚ Ховд аймагт аялал жуулчлалын бүтээгдэхүүн, нөөц, маршрут, хөтөч, жолооч, тогооч, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын бүртгэл, байршил, эвент бүтээгдэхүүнүүд зэрэг мэдээллүүдийг нэгтгэн сурталчилах, жуулчдыг мэдээлэлээр хангах зэрэг үйл ажиллагааг явуулах шаардлагатай байгаа учраас энэхүү хэрэгцээ шаардлагад тулгуурлан аялал жуулчлал мэдээлэлийн төвийг байгуулах ажлын саналыг Алтайн нүүдэлчид ТББ-аас Ховд аймгийн ЗДТГ-т хүргүүлсэнээр саналыг дэмжин 6,6 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 2015.11.17 наас аялал жуулчлал мэдээлэлийн төв, кофе шопын үйл ажиллагааг нээж эхлүүлээд байна. Аудитын явцад 6,6 сая төгрөгийг ТББ-д санхүүгийн дэмжлэгээр олгосон хөрөнгийг аймгийн БОАЖГ-ийн хөрөнгөнд орлого авхуулахаар албан шаардлага бичлээ.

3.7.Байгаль орчин ногоон хөгжлийн яамнаас өмнөх онууд хэрэгжүүлсэн, гэрээнд заасан баталгаат хугацаа үргэлжилж байгаа дараах ажлууд хангалтгүй хэрэгжсэн байна. Үүнд:

- ✚ Аймгийн Удирдлага, бодлого хэрэгжүүлдэг байгууллагуудаас Бичигтийн хөтөлд ойн зурвас байгуулах шийдвэр гаргасаны дагуу 2014 онд Байгаль орчны яаманд тендер зарлагдаж гүйцэтгэгч компаниудын дансанд санхүүжилт нь шууд олгогдсон байна. Ойн зурваст байгуулах ажилд Ховд Сафари ХХК, Үр жимс хоршоо , Жаргалант төгс ирээдүй хоршоо нь нийт 4800 м урт ойн зурвас байгуулжээ. Тус ойн зурваст нийт БОНХЯ-ны санхүүжилтээр 40,0 сая төгрөгт 12,0 мянган мод тарихаар гэрээ хийжээ. Ойн зурвас байгуулж буй газарт усгүй учраас Ховдын Эвлэл ХХК-иар түрээсийн тоног төхөөрөмжийн үнэд тооцон 2 ш худаг , Асьфаконстракшн компаниар Усны өргөлтийн магистриал шугам, ЦТСүлжээ ХХК-иар цахилгааны трансформатор, агаарын шугам татуулж усны асуудлыг шийдвэрлэсэн боловч тарисан мод дутуу, ургасан мод байхгүй байна. Тус газарт Босоо тэнхлэгийн замын трас дайрч байгаа тул буулгахаар болсон тухай Байгаль орчны дарга, аймгийн ЗДТГ-ыг мэргэжилтэн нар тайлбарлаж байна. **Ойн зурваст улсын болон орон нутгийн хөрөнгөөр хийсэн 100,0 гаруй сая төгрөгний хөрөнгө үрэгдсэн байна.**
- ✚ 2013 онд Ховд Тур ХХК нь мод тарих зориулалтаар 10,0 сая төгрөгний санхүүжилт авсан боловч нэг ч ширхэг мод ургаагүй, татсан хашаа нь зарим газраар унасан байна.

БҮЛЭГ 4: БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ТАВИХ ХЯНАЛТ:

Байгаль орчны чиглэлийн бүхий л байгууллагууд чиглэл чиглэлээрээ хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч зөрчил дутагдал буурахгүй байна .

4.1 Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Хар-Ус нуур орчмын УТХГН-ийн хамгаалалтын захиргаа, Зооноз өвчин судлалын төв, Жаргалант сум, Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтран БОНХ-ийн Сайдын 2014 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн “Агнуурын зарим амьтдыг агнах, түүхий эдийг түүж бэлтгэх, экспортлохыг түр хугацаагаар хориглох тухай” А/65 дугаар тушаалын хүрээнд хяналт шалгалтыг графикайн 4 ажлын хэсэгийн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэн ажиллаж байна.



4.2 Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдтэй сумдын байгаль хамгаалагчдаар дамжуулан хяналт хийдэг. МХГ, БОАЖГ азар, Сум дундын ойн анги, Хар –Ус нуур орчмын УТХГНХЗахиргаатай хамтран 2015 онд хяналт шалгалт хийх хуваарь гарган хяналтыг Их гүүр, Улаан богчийн рашаан, түлшний зах, постуудар 3-4 ээлжээр гарч ажилласан байна.

4.3 Байгаль хамгаалах сарын аяны хүрээнд Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хяналт шалгалт хийх ажлын хүрээнд Булган голын сав газрын захиргаа, сумын байгаль орчны алба хамтран эргүүлд 05-00 хүртэл цагийн хооронд зогсож хяналт тавьж ажилладаг байна.

4.4 Хууль бусаар ан амьтан агнах барих, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авах үйл ажиллагаанд Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Амьтны тухай” хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор Эрдэнэбүрэн, Мянгад, Дөргөн сумын нутаг дэвсгэрт 4 дүгээр сарын 22-27-ны өдрүүдэд “Загас хяналт-2015” хяналт шалгалт жил бүр зохион байгуулдаг.

4.5 Шижигтийн хавцлын загасны үржлийн гол хэсэг болох боргионы ширүүн урсгалтай /хүн загас барих боломж бүхий 2 цэг/ хэсгийг хашиж хамгаалан хүн оруулахгүй бүс тогтоож тэмдэгжүүлэх

Голын эргийн том үхэр чулуун дээр загас ирээд буцаж байгаа байдлыг харуулсан маршрутын зураг, хүний ухамсарт чиглэсэн оновчтой үг, хэллэг утга санааг агуулсан 272 километр замыг туулан ирж, түрсээ шахаад



буцдаг энэ үед загас агнахгүй байхыг сурталчилсан зурагт самбар хийх зэрэг ажлуудыг төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн байна.

4.6 Загасны үржлийн үеэр Буянт, Мянгад сум хариуцсан байгаль хамгаалагчид хяналт шалгалтын удирдамж гарган Ховд голын сав дагуу Хар ус

нуур, Ховд голын бэлчрээр эргүүл хийж, 66 дэгээ, 2 тор устгаж, 397 ширхэг гэрийн мод хураан авч сумын төсвийн орлогод оруулсан.

4.6 Сумдын байгаль хамгаалагчид жилийн хугацаанд давхардсан тоогоор 252 удаа хяналт шалгалт хийж 4500 гаруй хүнд сурталчилгааны ажлыг зохион байгуулж 3000 гаруй тараах материал хийж тараасан байна.

4.7 Мөнххайрханы БЦГ-ын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар давхардсан тоогоор 13 удаагийн хяналт шалгалт хийж 60 гаруй айл өрхөөр орж, 110 иргэнд хууль тогтоомж танилцуулан ажилласан. Тарваганы хяналт шалгалтын явцад тарвага агнахаар завдсан, хавх татсан зэрэг зөрчлүүдийг илрүүлэн нийт 33 хавх хурааж, 3 иргэнд 98,0 мянган төгрөгийн хураамж төлбөр ноогдуулсан байна.

4.8 Аялал жуулчлалын чиглэлийн хяналтаар зочин хүлээн авагч нь дүрэмт хувцасаа өмсөөгүй, гаднаас орж ирсэн зочдод хүндэтгэлгүй хандах, ажлын байраа орхиж явах, зарим өрөөний цэвэрлэгээ дутуу хийгдсэн, өрөөнд агаар оруулаагүй, зочид хүлээн авагчийн тэкний ард ор байрлуулсан, цахилгааны утас, залгуур зэргийг ил гаргасан зэрэг зөрчлүүд илэрсэн байсныг сануулж арилгахыг зөвлөсөн байна.

Аудитаар нийт 60,0 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага бичлээ.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- **Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг хэрэгжүүлэн орон нутагт хяналт тавих сумын ИТХ, сумын засаг дарга, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хуульд заасан үүргээ биелүүлээгүй байна**
- **Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогын бүрдүүлэлт хангалтгүй байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан заалтыг зөрчсөн байна.**
- **Байгаль орчны чиглэлийн бүхий л байгууллагууд чиглэл чиглэлээрээ хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч зөрчил дутагдал буурахгүй байна .**

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Н.Пүрэвганди, Аймгийн Засаг дарга Д.Галсандондог нарт:

- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгаль орчны салбарын байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, хуулийн хэрэгжилтэнд тавих дотоод хяналтыг эрчимжүүлэх

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулах
- Хууль бусаар байгалийн нөөцийг олборлож байгаа Өгөөжтэй өв ХХК, Ашид Алтай Майнинг ХХК-уудын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн байгууллагуудын хяналтыг эрчимжүүлж хяналтыг сайжруулах
- МУЗГ-ын 1997 оны 6 дугаар сарын 25-ны 152 дугаар тогтоол “ Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай ” тогтоолоор тогтоосон газрын суурь үнэлгээ өнөөдрийг хүртэл мөрдөгдөж байгаа нь өнөөгийн хэрэгцээ, шаардлаганд тохирохгүй байгаад дүгнэлт хийж МУЗГ-т асуудал боловсруулж газрын төлбөрийг нэмэгдүүлэх.

Аймгийн БОАЖГ-ын дарга З.Лхамхүүд.

- Жаргалант сумын Модон овооны чиглэлд ойн зурвас байгуулах ажилд хийгдсэн гэрээний хэрэгжилтийг гүйцэтгэгч компаниудаар хангуулан хэрэгжүүлээгүй ажлыг дахин хийлгэж төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх
- Өмнөх жилүүдэд болон 2016 онд ойжуулалтын ажил гүйцэтгэсэн компаниудын ажлын гүйцэтгэл, модны амьдралтын хувьд үндэслэн гэрээний үүргийн биелэлтийг хангуулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулах, улмаар өмнө онуудад ажлаа хангалтгүй хийсэн компаниудыг дараагийн ажлын гэрээ байгуулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Салбарын байгууллагуудыг бодлогоор ханган хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах
- Аймгийн хэмжээний байгаль орчныг чиглэлийн бодлого хэрэгжүүлэн ажиллаж байгаа мэргэжилтэнгүүдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх
- Байгаль орчны мэдээлэлийн сангийн баяжуулалтыг үнэн бодиттой хийж хэвших
- Дотоод хяналтыг эрчимжүүлсэн хэрэгжүүлсэн ажлын тайлан, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг гарган Аймгийн Аудитын газарт 2016 оны 12 сарын 15-ны дотор ирүүлэх

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ

ТАЙЛАНГ ХЯНАСАН :

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН :

АХЛАХ АУДИТОР

Д.ХИШГЭЭ

Тэргүүлэх Аудиторын тушаал:



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХОВД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 11 өдөр Дугаар 28 Ховд н

Аудитын тайлан, зөвлөмж, акт,
албан шаардлага батлах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалт Монгол Улсын Ерөнхий аудиторов 2003 оны 53 тоот тушаалаар баталсан "гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2, 2016 оны А/95 тоот тушаалаар баталсан "акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1, 4.1 дэх заалт, аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов дэргэдэх зөвлөлийн 2016 оны 10 сарын 11-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, Засгийн газрын тусгай сангийн зарцуулалтанд хийсэн нийцлийн аудитын тайлан, зөвлөмж, акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
2. Нийцлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга З.Лхамхүү-д ДААЛГАХ нь:
 - 2.1 Жаргалант сумын Модон овооны чиглэлд ойн зурвас байгуулах ажилд хийгдсэн гэрээний хэрэгжилтийг гүйцэтгэгч компаниудаар хангуулан хэрэгжүүлээгүй ажлыг дахин хийлгэж төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх
 - 2.2 Өмнөх жилүүдэд болон 2016 онд ойжуулалтын ажил гүйцэтгэсэн компаниудын ажлын гүйцэтгэл, модны амьдралтын хувьд үндэслэн гэрээний үүргийн биелэлтийг хангуулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулах, улмаар өмнө онуудад ажлаа хангалтгүй хийсэн компаниудыг дараагийн ажлын гэрээ байгуулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
 - 2.3 Салбарын байгууллагуудыг бодлогоор ханган хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах
 - 2.4 Аймгийн хэмжээний байгаль орчныг чиглэлийн бодлого хэрэгжүүлэн ажиллаж байгаа мэргэжилтэнгүүдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх
 - 2.5 Байгаль орчны мэдээллийн сангийн баяжуулалтыг үнэн бодиттой хийж хэвших

2.6 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулах

2.7 Байгаль хамгаалах сангийн дансдыг сумдын төрийн санд нээж орлого зарлагын гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах

3. Нийцлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Хөгжил Политехник коллежийн захирал Д.Баярмаа, Ерөнхий нягтлан бодогч М.Өлзийхишиг нарт ДААЛГАХ нь:

3.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах талаар аймгийн ИТХ-д уламжлан санхүүгийн дэмжлэг авах, орон нутгийн төсөвт тусгаж батлуулж үр өгөөжийг дээшлүүлэх

3.2 Сургалтын материаллаг бааз, боловсон хүчний нөөц бололцоогоо ашиглан сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор туслах аж ахуйгаас орох орлогын тодорхой хувийг сангийн үйл ажиллагаанд зарцуулах талаар анхааран ажиллах.

4. Нийцлийн аудитын зөвлөмж тавьсан акт, албан шаардлагыг барагдуулж дүнг 11 сарын 10-ны дотор танилцуулахыг аудит хийсэн аудитор, шинжээч нарт хариуцуулсугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ



Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:

**ХОВД АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

84149 Ховд аймаг, Жаргалант сум, Наран баг,
Утас: (976) 7043-3038

2016.10.12 № 223

танай _____-ны № _____-т

Тайлбар хүргүүлэх тухай

Ховд аймгийн Аудитын газраас 2016 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн 1/13 тоот ирүүлсний дагуу үйл ажиллагаанд 4 бүлэг сэдвээр хяналт хийж хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөнийг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А-232 дугаар тушаал, Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын сайдын 2015 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А-76 тоот тушаал, Ховд аймгийн Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А-85 тоот захирамжийн гуравт Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг зааж өгсөний дагуу үйл ажиллагааг явуулж байна. Аудитын шалгалтын

1 дүгээр бүлэгт: Аймаг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй гэсэн дүгнэлтийг зөвшөөрөхгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр 2015 онд Засгийн газрын тогтоол, шийдвэрийн 41 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг тооцоход 80,6%-ийн хэрэгжилттэй байлаа.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд 14 ажил тусгагдаж, биелэлт 94,4%-тай хэрэгжсэн.

2015 оны жилийн эцсийн байдлаар Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн ээлжит болон ээлжит бус хуралдаан, тэргүүлэгчдийн тогтоол, хуралдааны тэмдэглэл нийт 10 эрх зүйн акт хяналтанд авч, 85,5%-тай хэрэгжсэн.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт байгаль орчны чиглэлийн 28 заалт тусгагдсан нь 2015 оны жилийн эцсийн байдлаар 70%-тай хэрэгжсэн. / 2016 оны ажил тооцогдоогүй/

Аймгийн нийгэм эдийн засгийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 21 заалт тусгагдсаныг 80%-тай биелүүлсэн.

Тус байгууллагын төсвийн шууд захирагчийн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт 89,9%-тай дүгнэгдсэн.

Учир нь 2015 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 8 тушаал, Төрийн нарийн бичгийн 3, Аймгийн ИТХ-аас 10 тогтоол, Засаг даргаас 9 захирамж, 3 албан даалгавар, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 12 тогтоол, Сумын Засаг даргын 28 захирамж нийт 73 эрх зүйн акт гарч бүрэн хэрэгжсэн.

2,3 дугаар бүлэгт: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт хангалтгүй гэжээ.

Байгаль хамгаалах сан 2012 онд татан буугдсан 2014 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 43 дугаартай "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам" гарсан боловч байгаль хамгаалах чиглэлийн "Сан", "Данс" орон даяар байхгүйгээс хэрэгжих нөхцөл бүрдэхгүй байна.

4 дүгээр бүлэгт: Байгаль орчны чиглэлийн байгууллагууд Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Сав газрууд, Тусгай хамгаалалттай газар нутгуудын хамгаалалтын захиргаа, Ус цаг уур орчны

1601 А420173

шинжилгээний алба хамтарсан хяналтуудыг график гаргаж жилд дунджаар 8 удаа төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналтыг сар улирлаар зохион байгуулсны дүнд Байгаль орчны хууль бус зөрчлүүд эрс буурсан.

ДАРГА  ЗЛХАМХҮҮ

САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР:

Тайлбар 1. 1 дүгээр бүлэгт тусгагдсан асуудлыг тайланд тусгасан. Аймгийн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хянах явцад аудитад ирүүлсэн нотлох зүйл, илрүүлсэн алдаа, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, тайлан мэдээ, судалгаанаас үндэслэн аудитын ерөнхий дүгнэлтийг өгсөн тул саналыг хүлээн авах боломжгүй

Тайлбар 2. Байгаль хамгаалах сангийн тайланд дүгнэлт өгч тусгасан.

Тайлбар 3. Салбарын байгууллагуудын хэрэгжүүлсэн хяналтын талаар тус тайлангийн 4 дүгээр бүлэгт тусгасан болно.